

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Боржигин чуулгын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/18/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: Г.Ариунцэцэг Цахим хаяг: Ariuntsetsegg@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2024.02.23 № 30

танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боржигин чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Боржигин чуулгын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үүнд:

1. Тайланд онд бусад хангамжийн материалын дансанд 1,357,0 мянга, бэлэн бүтээгдэхүүн дансанд 4,639.1 мянга, нийт 5,996.1 мянган төгрөгийн орлого, зарлагыг тайлагнасан боловч нярав бараа материалын тайланг бэлтгэж ирүүлээгүй.
2. Зардлын ангилал зөрчиж багаж техник хэрэгслийн зардлаас 4,430.0 мянган төгрөгийн тавилга худалдан авч, зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
3. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан. Үүнд: Спиннинг клубт 660.0 мянга, ширээний теннисний клубт 120.0 мянга, фитнес клубт 210.0 мянга, усан спорт сургалтын төвд 900.0 мянган төгрөг тус тус шилжүүлж, нийт 1,890.0 мянган төгрөгийг үр ашиггүй зардалд зарцуулсан.
4. Бараа материалын 10-12 сарын шатахуун зарцуулалтын тайланд жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт бичээгүй, 2,309.2 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу.

0008020105

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Говьсүмбэр аймгийн Боржигин чуулга нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 3 зорилт 53 арга хэмжээг тусгаж Соёл урлагийн газрын даргаар батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 87 хувьтай дүгнэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	310,130,264.40	542,633,478.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,866,480.40	155,594,694.86
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,866,480.40	155,594,694.86
31210	Төгрөг	2,866,480.40	155,594,694.86
31211	Төрийн сангийн харилцах	1,853,676.40	130,481,890.86
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,012,804.00	25,112,804.00
35	БАРАА МАТЕРИАЛ	307,263,784.00	387,038,784.00
35100	Түүхий эд материал	193,385,689.00	228,018,189.00
35110	Тусгай зориулалттай материал	193,385,689.00	228,018,189.00
35400	Хангамжийн материал	113,878,095.00	159,020,595.00
35420	Аж ахуйн материал	90,109,295.00	114,112,795.00
35450	Барилгын засварын материал	308,000.00	308,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,460,800.00	44,599,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	812,608,270.53	764,138,605.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	812,608,270.53	764,138,605.29
39200	Биет хөрөнгө	751,815,410.45	707,306,745.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	765,133,399.00	765,133,399.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-68,062,847.20	-89,061,020.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,800,000.00	12,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,533,333.44	-12,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	68,849,041.00	81,990,241.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,563,395.93	-65,511,126.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,037,768.00	57,867,768.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,726,471.10	-44,598,453.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	49,649,174.60	49,649,174.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-46,767,924.48	-48,163,236.88
39300	Биет бус хөрөнгө	60,792,860.08	56,831,859.88
39301	Програм хангамж	875,000.00	875,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-774,999.92	-875,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,414,860.00	68,414,860.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-7,722,000.00	-11,583,000.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,122,738,534.93	1,306,772,084.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	337,479.54	180,739.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	337,479.54	180,739.17
41300	Өглөг	337,479.54	180,739.17
41360	Бусад өглөг	337,479.54	180,739.17
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	337,479.54	180,739.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,122,401,055.39	1,306,591,344.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,122,401,055.39	1,306,591,344.98
51100	Засгийн газрын оруулсан капитал	479,014,514.00	479,014,514.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	479,014,514.00	479,014,514.00
51200	Хуримтлагдсан үр дүн	160,688,245.40	344,878,534.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-959,714,605.99	160,688,245.40
51220	Тайлант үеийн үр дүн	1,120,402,851.39	184,190,289.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	482,698,295.99	482,698,295.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,122,738,534.93	1,306,772,084.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,012,379,453.37	1,534,036,677.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,160,947,953.37	49,968,226.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,160,947,953.37	49,968,226.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	55,393,350.00	34,468,226.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,393,350.00	34,468,226.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	854,636,169.37	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	250,918,434.00	15,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	851,431,500.00	1,484,068,451.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	774,958,700.00	1,388,446,451.33
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	774,958,700.00	1,388,446,451.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	14,000,000.00
131102	Хаагдсан данс	0.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	14,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,472,800.00	81,622,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,472,800.00	81,622,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	891,976,601.98	1,349,846,387.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,976,601.98	1,349,846,387.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,481,101.98	1,150,483,465.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,388,620.60	842,247,098.27
210101	Үндсэн цалин	459,048,049.60	594,277,288.86
210102	Нэмэгдэл	80,131,492.00	131,929,529.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,963,872.00	45,708,440.68
210104	Урамшуулал	28,245,207.00	70,331,839.07
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,455,417.54	106,829,307.23
210201	Тэтгэврийн даатгал	55,568,529.94	82,610,760.69
210202	Тэтгэмжийн даатгал	7,063,889.63	6,235,066.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,160,479.25	4,882,473.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,259,563.30	1,190,982.01
210205	Эрүүл мэндийн даатгал	7,402,955.42	11,910,025.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,459,821.00	74,372,126.20
210301	Гэрэл, цахилгаан	5,069,454.00	6,340,393.20
210302	Түлш, халаалт	62,661,622.00	62,024,593.00
210303	Цэвэр, бохир ус	8,728,745.00	6,007,140.00
210304	Байрны түрээс	0.00	0.00

2104	Хангамж, бараа материалын зардал	5,609,840.00	10,882,778.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	3,219,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,632,750.00	3,847,578.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	857,090.00	941,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,130,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	1,503,700.00
2105	Нормативт зардал	322,600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,553,750.00	3,967,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	11,053,750.00	3,967,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,973,000.00	7,150,000.00
210702	Дотоод албан томилолт	1,973,000.00	7,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,105,234.00	31,216,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,630,734.00	30,621,641.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	121,500.00	119,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	293,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	180,000.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,612,818.84	73,817,765.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,084,920.00	8,376,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,527,898.84	65,440,865.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,495,500.00	199,362,921.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,495,500.00	196,113,048.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	2,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	39,335,648.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	150,009,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,495,500.00	4,518,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,249,873.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,249,873.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,120,402,851.39	184,190,289.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,120,402,851.39	184,190,289.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	909,297,654.00	1,543,536,677.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,294,054.00	73,468,226.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,294,054.00	59,468,226.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,294,054.00	34,468,226.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,821,250.00	31,191,926.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,276,300.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	2,472,804.00	0.00
120009	Бусад орлого	0.00	25,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	14,000,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	14,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	903,003,600.00	1,470,068,451.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	774,958,700.00	1,388,446,451.33
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	774,958,700.00	1,388,446,451.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,572,100.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,572,100.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,472,800.00	81,622,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,472,800.00	81,622,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	887,931,173.60	1,373,837,262.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,931,173.60	1,373,837,262.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	879,435,673.60	1,174,474,341.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	623,450,749.60	867,374,994.06
210101	Үндсэн цалин	458,863,964.60	619,423,374.68
210102	Нэмэгдэл	80,786,833.00	131,913,989.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,963,872.00	45,705,790.94
210104	Урамшуулал	28,836,080.00	70,331,839.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,530,409.00	106,858,151.81
210201	Тэтгэврийн даатгал	53,566,873.59	82,639,605.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,281,896.44	6,235,066.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,419,492.25	4,882,473.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,242,063.30	1,190,981.20
210205	Эрүүл мэндийн даатгал	8,020,083.42	11,910,025.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,459,821.00	74,372,126.20

210301	Гэрэл, цахилгаан	5,069,454.00	6,340,393.20
210302	Түлш, халаалт	62,661,622.00	62,024,593.00
210303	Цэвэр, бохир ус	8,728,745.00	6,007,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,609,840.00	9,359,178.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	3,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,632,750.00	3,847,578.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	857,090.00	941,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,130,000.00
2105	Нормативт зардал	322,600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,553,750.00	15,753,020.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	11,709,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	43,120.00
210604	Урсгал засвар	11,053,750.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,973,000.00	7,150,000.00
210702	Дотоод албан томилолт	1,973,000.00	7,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,075,504.00	84,158,571.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,601,004.00	83,565,221.00
210803	Даатгалын үйлчилгээ	121,500.00	119,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	293,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,460,000.00	9,448,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,460,000.00	9,448,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,495,500.00	199,362,921.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,495,500.00	196,113,048.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	2,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	39,335,648.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	150,009,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,495,500.00	4,518,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,249,873.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,249,873.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,366,480.40	169,699,414.46
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,500,000.00	16,971,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,500,000.00	16,971,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,500,000.00	16,971,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,500,000.00	16,971,200.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-18,500,000.00	-16,971,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,866,480.40	152,728,214.46
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,866,480.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,866,480.40	155,594,694.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	479,014,514	482,698,295	-959,714,605.9	1,998,204
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	479,014,514	482,698,295	-959,714,605.9	1,998,204
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,120,402,851.3	1,120,402,851
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,014,514	482,698,295	160,688,245.4	1,122,401,055
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	479,014,514	482,698,295	160,688,245.4	1,122,401,055
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	479,014,514	482,698,295	160,688,245.4	1,122,401,055
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	184,190,289.5	184,190,289
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	479,014,514	482,698,295	344,878,534.9	1,306,591,344

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,459,144,700.00	1,308,286,462.87	1,308,286,462.87	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,144,700.00	1,308,286,462.87	1,308,286,462.87	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,237,859,300.00	1,112,173,414.87	1,112,173,414.87	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	952,963,900.00	867,374,994.06	867,374,994.06	0.00
210101	Үндсэн цалин	627,473,700.00	619,423,374.68	619,423,374.68	0.00
210102	Нэмэгдэл	145,748,000.00	131,913,989.37	131,913,989.37	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,233,300.00	45,705,790.94	45,705,790.94	0.00
210104	Урамшуулал	126,508,900.00	70,331,839.07	70,331,839.07	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,799,700.00	106,858,151.81	106,858,151.81	0.00
210201	Тэтгэврийн даатгал	81,556,500.00	82,639,605.75	82,639,605.75	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,560,800.00	6,235,066.59	6,235,066.59	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,648,400.00	4,882,473.27	4,882,473.27	0.00

210204	Ажилгүйдлийн даатгал	1,912,200.00	1,190,981.20	1,190,981.20	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,121,800.00	11,910,025.00	11,910,025.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	0.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	0.00	0.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	0.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	0.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,505,200.00	9,359,178.00	9,359,178.00	0.00
210401	Бичиг хэрэг	3,200,000.00	3,200,000.00	3,200,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	3,855,200.00	3,847,578.00	3,847,578.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	941,600.00	941,600.00	0.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	240,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,130,000.00	1,130,000.00	1,130,000.00	0.00
2105	Нормативт зардал	322,600.00	0.00	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	0.00	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,890,600.00	28,724,220.00	28,724,220.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,681,100.00	28,681,100.00	28,681,100.00	0.00
210602	Тавилга	0.00	0.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	209,500.00	43,120.00	43,120.00	0.00
210604	Урсгал засвар	0.00	0.00	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	7,163,900.00	7,150,000.00	7,150,000.00	0.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,163,900.00	7,150,000.00	7,150,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,808,000.00	84,158,571.00	84,158,571.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,175,100.00	83,565,221.00	83,565,221.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,900.00	119,850.00	119,850.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	293,500.00	293,500.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	0.00	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00	180,000.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00	0.00	0.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,405,400.00	8,548,300.00	8,548,300.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,405,400.00	8,548,300.00	8,548,300.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221,285,400.00	196,113,048.00	196,113,048.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,285,400.00	196,113,048.00	196,113,048.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,250,000.00	2,250,000.00	2,250,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,508,000.00	39,335,648.00	39,335,648.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	150,009,400.00	150,009,400.00	150,009,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,518,000.00	4,518,000.00	4,518,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,459,144,700.00	1,422,914,677.33	1,436,914,677.33	-14,000,000.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,402,446,300.00	1,388,446,451.33	1,404,822,751.33	-16,376,300.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,402,446,300.00	1,388,446,451.33	1,404,822,751.33	-16,376,300.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,698,400.00	34,468,226.00	32,091,926.00	2,376,300.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,636,900.00	31,191,926.00	28,815,626.00	2,376,300.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,276,300.00	3,276,300.00	3,276,300.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	785,200.00	0.00	0.00	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,853,676.40	0.00	1,853,676.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	130,481,890.86	0.00	130,481,890.86
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57.00	57.00	0.00	57.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	0.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	0.00	7.00
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57.00	57.00	0.00	57.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	0.00	7.00
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1.00	1.00	0.00	1.00
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1.00	1.00	0.00	1.00

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 2,381.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	648.0	2	648.0	100%
Албан шаардлага	1		1		100%
Зөвлөмж	1		1		100%
Нийт дүн	4	648.0	4		100%

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,019.0 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 133,019.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Тайлант хугацааны санхүүгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 15,500,000 төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн, Төвлөрүүлэх шилжүүлгийн 3,249,873 төгрөгийг үр дүнгийн тайланд бүртгээгүй, ахмадын санд төвлөрүүлсэн 25,000,000 төгрөгийг орлогоор бүртгэсэн зэргээр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, ангилал, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй
2. Хөрөнгийг орлогод бүртгэхдээ нэгжийн үнэ, тоо ширхгийг зөрүүлж буруу дансанд бүртгэсэн, үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд орлого авч тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.
3. Ажиллагсдад 11, 12 дугаар сард олгосон урьдчилгаа цалингийн дансны бичилтийг цалингийн өглөг дансанд тусгаж буруу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4-т заасныг тус тус зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Аудитаар нийт 15,490.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,755.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,426.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, 2,309.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1. Төлбөрийн акт

5.1.1. Тайлант оны 1 дүгээр сард ажил тасалсан 8 албан хаагчид нийт 491.5 мянган төгрөгийн 13 өдрийн цалин бодож олгосон.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дугаар зүйл, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан. Үүнд: Спиннинг клубт 660.0 мянга, ширээний теннисний клубт 120.0 мянга, фитнес клубт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

210.0 мянга, усан спорт сургалтын төвд 900.0 мянган төгрөг тус тус шилжүүлж, нийт 1,890.0 мянган төгрөгийг үр ашиггүй зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Суманд 1 хоногоор ажилласан 3 ажилтанд буудлын мөнгө олгож, төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэлт: Илүү олгосон томилолтын зардлыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.4 Жилийн эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцооллыг тулган баталгаажуулж хянаагүйгээс ажилчдаас 104,000 төгрөгийг илүү, 80,000 төгрөгийг дутуу суутгаж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэлт: Илүү суутгасан татварын хөнгөлөлтийг буцаан олгох, дутуу тооцсон хөнгөлөлтийг суутгаж авах төлбөрийн акт тогтоов.

5.1.5 Жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг 1 ажилтанд тушаалд заасан хувиас багаар тооцсоноос нийт 70.2 мянган төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон үр дүнгийн урамшууллыг албан хаагчид нөхөн олгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Багаж техник хэрэгслийн зардлаас 4,430.0 мянган төгрөгийн тавилга худалдан авч, зардлыг зориулалт бусаар зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант онд бусад хангамжийн материалын дансанд 1,357,000, бэлэн бүтээгдэхүүн дансны 4,639,076 төгрөгийн орлого, зарлагыг тайлагнасан боловч нярав бараа материалын тайланг бэлтгэж ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нярав анхан шатны баримтад үндэслэсэн иж бүрэн тайланг сар бүр бэлтгэн нягтлан бодогчид өгч хянуулах, нягтлан бодогч, няравтай сар бүр тооцоо нийлж, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны 10-12 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу, спидометрийн заалт бичээгүй жолоочийн тооцооны хуудсаар нийт 2,309.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Шатахууны тайлангийн анхан шатны баримтын бүрдлийг хангах, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох журам, зааврыг мөрдөж, иж бүрэн хөтлөх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боржигин чуулга	3	133,019.0			3	133,019.0	3	133,019.0				
Дүн	3	133,019.0			3	133,019.0	3	133,019.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Боржигин чуулга	8	15,490.9	5	2,755.7	2	10,426.0	1	2,309.2				
Дүн	8	15,490.9	5	2,755.7	2	10,426.0	1	2,309.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Боржигин чуулга	1							1
Дүн	6				1	625,449.0	5	
Нийт дүн	17	773,959.0	5	2,755.7	3	635,875.0	6	2,309.1

Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гагасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		